



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**“БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ
ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТ”-Д ХИЙСЭН
НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН**

2023 он


Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудит



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудит



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудит



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудит

№	Байгалийн нөөц	Татварын хэлтсээс хүргүүлсэн БНАТ-ийн орлогын санал				Сангийн яамнаас баталсан БНАТ-ийн орлогын төлөвлөгөө			
		2021 он	2022 он	2023 он	Нийт дүн	2021 он	2022 он	2023 он	Нийт дүн
1	Ан амьтан	-	-	-	-	-	20.0	40.0	60.0
2	Усны нөөц	350.0	413.1	450.0	1,213.1	400.0	581.0	787.0	1,768.0
3	Газрын төлбөр	205.0	350.0	386.0	941.0	350.0	389.0	499.0	1,238.0
Нийт дүн		555.0	763.1	836.0	2,154.1	750.0	990.0	1,326.0	3,066.0

Ан амьтны нөөцийн орлогын төлөвлөгөөний санал хүргүүлээгүй байхад 2022 онд 20.0 сая, 2023 онд 2 дахин нэмэгдүүлж 40.0 сая төгрөгөөр баталсан байна.


Огноо	Ногдуулсан орлого	Төвлөрүүлсэн орлого	Дутуу төвлөрүүлэлт	Хувь
2021 он	828.3	702.5	125.8	84.8%
2022 он	841.2	643.6	197.6	76.5%
Нийт дүн	1,669.5	1,346.1	323.4	80.6%

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн ногдуулсан орлогыг жил бүр дутуу төвлөрүүлж ирсэн байна. Үүнийг “Шивээ-овоо” ХК-ны нүүрсний борлуулалтын орлого өсөхгүй байгаатай холбоотой гэсэн тайлбарыг өгсөн байна.

2021-2023 онд БХНСАХЗ-ыг хуульд заасан орлогын доод хэмжээгээр тооцож төлөвлөөгүй бөгөөд нийт дүнгээрээ 429.4 сая төгрөг буюу 41.8%-аар дутуу төлөвлөж батлуулсан байна.


огноо	Ан амьтан		Усны төлбөр		Газрын төлбөр		Ойн нөөц		Нийт дүн	
	Хуулийн 18.1 доод хувиар тооцсон	АИТХ	Хуулийн 18.1 доод хувиар тооцсон	АИТХ	Хуулийн 18.1 доод хувиар тооцсон	АИТХ	Хуулийн 18.1 доод хувиар тооцсон	АИТХ	Хуулийн 18.1 доод хувиар тооцсон	АИТХ
2021 он	-	35.40	140.0	33.70	52.50	13.20	-	56.10	192.50	138.40
2022 он	10.00	13.80	203.30	6.50	58.30	-	-	208.70	464.10	229.00
2023 он	20.00	11.90	275.40	38.30	74.80	-	-	179.80	370.20	230.00
Нийт дүн	30.00	61.10	618.70	78.49	185.6	13.20	-	444.6	1,026.8	597.4

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудит



2022

Байгалийн нөөц
ашигласны төлбөрийн
тухай хуулийн
хэрэгжилт



2021

Байгалийн нөөц
ашигласны төлбөрийн
тухай хуулийн
хэрэгжилт



ДҮГНЭЛТ

Бүлэг 1

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн зарим заалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байна.
- Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдуулан менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.
- Сумдын Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар арга хэмжээ тусгаагүй байна.

Бүлэг 2

- Орон нутгийн хэмжээнд ой, ан агнуур, усны нөөцийг тогтоосон байна.
- 2023 оноос эхлэн төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.
- БНАТ-ийн зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгосон байна.
- БНАТ-ийн орлогын төлөвлөгөө 2022 онд 323.4 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.
- БНАТ-ийн төлбөрийн орлогоос тооцсон БХНСАХЗ-ыг хуульд заасан доод хувь хэмжээнээс 41.8%-аар дутуу баталсан байна.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Бүлэг 3

- Цахим мэдээллийн санд мэдээллийг зөрүүтэй оруулсан байна.
- Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа үр дүнгүй, уялдаа холбоогүй байна.
- Аймаг, сумдын ИТХ, Мэргэжлийн байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.
- БОАЖЯ-аас 2022 онд БНАТ-ийн хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргад хүргүүлсэн чиглэлийг хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аймаг, сумдын Иргэдийн
төлөөлөгчдийн хурлын дарга
нарт

- БНАТ-ийн хуульд заасан чиг үүргийн хүрээнд мэргэжлийн байгууллагатай хамтран төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах, үр дүнг тооцох, хуулийн хэрэгжилтийг хангуулах

Аймгийн Байгаль, орчин аялал
жуулчлалын газарт

- Цахим мэдээллийн санд /www.eic.mnp/ байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх төлбөрийн орлогын гүйцэтгэл, зарцуулалтыг үнэн зөв мэдээлэх, мэдээллийн үнэн зөв эсэхэд хяналтыг хэрэгжүүлэх, дутуу мэдээллийг нөхөн мэдээлэх

Аймгийн Татварын хэлтэст

- Усны болон газрын төлбөрийн орлогод хяналт тавьж ажиллах, хуулийг хамтран хэрэгжүүлж байгаа байгууллагуудтай хамтарч ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулах

Аймгийн Засаг даргад

- Сумдын Засаг дарга нартай байгуулах хамтран ажиллах гэрээнд БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг тусгайлан тусгах

Сүмбэр сумын Засаг даргад

- Хуулиар хүлээсэн эрх үүргээ биелүүлж, нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, үр дүнг сумын ИТХ-д тайлагнах

Аймгийн Санхүү, төрийн
сангийн хэлтэст

- Аймгийн БОАЖГ-аас ирүүлсэн “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ”-ний хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн төсвийн төслийн саналыг хүлээн авах, төсвийн төслийг бодитой хянах

Сумдын Засаг даргын тамгын
газарт

- БНАТ-ийн хуулийн дагуу орлогын төлөвлөгөө болон зарцуулалтын тайлан, БХНСАХЗ-ын төсвийн төслийн санал, гүйцэтгэлийг бодитой төлөвлөж, тайлагнах
- Цахим мэдээллийн санд /www.eic.mnp/ байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх төлбөрийн орлогын гүйцэтгэл, зарцуулалтыг үнэн зөв мэдээлэх, мэдээллийн үнэн зөв эсэхэд хяналтыг хэрэгжүүлэх, дутуу мэдээллийг нөхөн мэдээлэх

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 25 дугаар зүйлд “Сумын Засаг дарга саналаа хүргүүлээгүй, хүргүүлсэн боловч сумын ИТХ нь батлаагүй, саналыг үндэслэлгүй өөрчилж баталсан зэрэг тохиолдолд хэрхэн хариуцлага хүлээлгэх” талаар тусгайлан заалт оруулах”



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлд 20.1-д “нийтийн эзэмшлийн гудамж талбай ногоон байгууламжийн усалгаанд зориулж буй усыг усны төлбөрөөс чөлөөлөх” гэсэн заалт нэмж оруулах



Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.5, 2.6, 3 дугаар зүйлийн 3.8, 3.9-д заасан хугацааг ялгаатай болгох



Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлд “Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого бүрдүүлдэггүй говийн аймгуудад ойжуулалт хийх, мод үржүүлэг, тарьц суулгацын нөөц бүрдүүлэх, усалгаа, арчилгаанд зарцуулах зардлыг тооцох тусгайлсан заалт” нэмж оруулах



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд “Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга, Иргэдийн хурлын эрх, үүрэг” гэсэн хэсэг нэмж оруулах



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5, 18 дугаар зүйлийн 18.1.3-д заасан “Газрын нөөц” гэсэн ойлголтыг Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуульд тодотгож оруулах



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА

Дэлгэрэнгүй дараах холбоосоор орж үзнэ үү.
www.audit.mn